



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.06.20 № 184
танай _____-ны № _____-т

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай
хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитын тайланг
хүргүүлж байна.

Хавсралт: ²⁰.....хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 1/10

Эрдэнэт

**Аудитын тайланг баталгаажуулах
тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг"-ийн 2.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт" нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Баян-Өндөр сумын Засаг дарга, Жаргалант сумын Засаг дарга, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг холбогдох төсвийн захирагчдаар арилгуулах, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Батжаргал /-д зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Буян-Ундрах/, ахлах аудитор /В.Жавзмаа/, аудитор /Б.Азжаргал, Б.Бямбагтох/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудиторын
2023 оны 06 дугаар сарын 09 өдрийн
дугаар тушаалын хавсралт

6117143690
ΦAA0073 9042806

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Дугаар	Зөрчлийн товч утга	Зөрчил хариуцагч байгууллага	Төлбөрийн акт, Албан шаардлага хариуцагч		Албан шаардлага дүн	Төлбөрийн акт дүн
			Албан тушаал	Нэр		
147/A1460335 ОРА-2023/30-13-ШТА-НА	Ойгоос мод бэлтгэж ашигласны төлбөр 2,349,880 төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.	Жаргалант сумын ЗДТГ	Дарга, Санхүү албаны дарга, Байгаль хамгаалагч	Т.Энхжаргал, Ч.Буянаа, Н.Бямбажин		2,349,880
136/A1460335 ОРА-2023/30-13-ШТА-НА	Эрх бүхий байгууллагын ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, ус ашиглах гэрээгүйгээр 6 аж ахуй нэгж үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар 2021-2023 онуудад ус ашигласан байна.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Дарга, мэргэжилтэн	С.Жаргалсайхан П.Одончимэг	-	
Нийт дүн					-	2,349,880

Төлбөрийн акт, албан шаардлагыг хариуцагч байгууллагуудад эх хувиар хүргүүлсэн, зөрчлийг дэлгэрэнгүй тайланд тусгасан.

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

ОРЛОГЫГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЖ, ЖУРМЫН ДАГУУ ЗАРЦУУЛАХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Аудитын код: ОРА-2023/30-13-ШТА-НА

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Ахлах аудитор: В.Жавзмаа
Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn
Аудитор: Б.Азжаргал
Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn
Аудитор: Б.Бямбатогтох
Утас: 70357955 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн товъёг.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	5
БҮЛЭГ 1. Байгалийн нөөцийг ашиглах төрийн бодлогын хэрэгжилт тодорхой түвшинд хангагдаж буй ч бусад хууль, журамтай нийцүүлэхээр байна.	6
1.1. Аймгийн хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт 90 гаруй хувьтай байна.....	6
1.2 Байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг 2023 оны эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд тусгаж эхэлсэн байна.....	8
БҮЛЭГ 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журамтай бүрэн нийцээгүй байна.....	9
2.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, ногдуулалт, төвлөрүүлэлтэд тавих хяналт сул байгаагаас орлого бүрэн төвлөрөөгүй байна.....	9
2.2 Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээг мөрдөхгүй төлөвлөж, журамд нийцээгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.	13
БҮЛЭГ 3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгээгүйгээс олон нийтийг мэдээллээр хангах, хяналт тавих боломж бүрдээгүй байна.	14
3.1 Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, төрийн байгууллагуудын уялдаа холбоог оновчтой болгох шаардлагатай байна.....	15
3.2 Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.	16
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	16
ЗӨВЛӨМЖ:	17
Холбогдох байгууллагын санал:	18

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлт	7
Хүснэгт 2	Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт	7
Хүснэгт 3	Төсөв захирагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	9
Хүснэгт 4	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, биелэлт	11
Хүснэгт 5	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөлт	14
Хүснэгт 6	Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэл	14

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит үндэслэл, хийх бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-ний дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ. • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх. • Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх. • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Сэлэнгэ голын сав газрын захиргаа, Татварын хэлтэс, Сум дундын ойн ангийн 2021-2023 оны үйл ажиллагааны мэдээ, тайлан, дүгнэлт, гэрээ гэх зэрэг баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав. Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

	Аудитад дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд: • Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль • Хууль тогтоомжийн тухай хууль • Байгаль орчныг хамгаалах тухай хууль • Ойн тухай хууль • Усны тухай хууль • Амьтны тухай хууль • Газрын тухай хууль • Байгалийн ургамлын тухай хууль • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль • Төсвийн тухай хууль • Шилэн дансны тухай хууль • Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” • Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” • “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021 оноос 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол) • Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Б.Азжаргал, Б.Бямбатогтох нар 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.
Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл	Үүсээгүй болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, 6.2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж заасан.

Байгаль орчны салбарт 2020 оны байдлаар Монгол Улсын нэгдэн орж соёрхон баталсан 22 олон улсын гэрээ, конвенц, богино, дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэх 20 бодлого, хөтөлбөр, салбарын болон салбар дундын 38 хууль, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй 95 журам, аргачлал, тус салбарт шууд хамаарах 434 үндэсний стандарт мөрдөгдөж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 2012 онд батлагдсан бөгөөд төлбөрийн хувь хэмжээ, төлбөрөөс чөлөөлөгдөх хөнгөлөх, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хүрээнд 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Аймгийн нийт нутаг дэвсгэр 84,400.0 га бөгөөд үүнээс 46,245.0 га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 20,687.33 га нь хот, тосгон, суурин газар, 1,213.28 га нь зам, шугам сүлжээний газар, 15,893.1 га нь ойн сан бүхий газар, 221.5 га нь усан сан бүхий газар, 139.79 га нь улсын тусгай хэрэгцээний газар байна.

Ойн сангийн нийт талбайн 85.5 хувийг ойн талбай, 14.5 хувийг ойн бус талбай эзэлж байна.

Аймгийн нутаг дэвсгэрт 46 овог 154 төрөлд хамаарах 235 зүйл ургамалтайгаас 204 зүйл эмийн болон ашигт ургамал бүртгэгдсэн байна.

Орхон аймаг 2021-2022 онд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогод 42,919.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 1. Байгалийн нөөцийг ашиглах төрийн бодлогын хэрэгжилт тодорхой түвшинд хангагдаж буй ч бусад хууль, журамтай нийцүүлэхээр байна.

1.1. Аймгийн хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт 90 гаруй хувьтай байна.

A1.1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг зарим хууль, журамтай нийцүүлэхээр байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг зарим хууль, тогтоомжтой нийцүүлэхээр байна. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т “Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хуульд заасны дагуу тогтооно” гэж заасан боловч тухайн хуулийг батлаагүй;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан боловч Зөрчлийн тухай хуульд байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг тусгаагүй;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ”, 23.3-т “Сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан төлбөрийг бэлнээр хураан авсан тухай бүр сум, дүүргийн төсөвт тушаана” гэж заасныг цахим төлбөр тооцооны баримт үүсгэх, ногдуулалт, төлбөр төлүүлэх талаар тусгаагүй бөгөөд цаашид цахим болгох шаардлага үүссэн;
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/282 дугаар тушаалаар баталсан "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам", Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хугацаа цаглабрыг зөрүүтэй тусгасан.

A1.2. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт 90 гаруй хувьтай байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд Орхон аймаг, Эрдэнэт хотын ногоон тогтвортой хөгжлийн хэтийн зорилт – 2025 бодлогын баримт бичгийг боловсруулсан байна.

Аймгийн ногоон хөгжил зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг Орхон аймаг, Эрдэнэт хотын ногоон тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025, аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичгүүдэд дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт №1. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлт

№	Бодлогын баримт бичиг	Дэвшүүлсэн зорилт	Арга хэмжээ	Санхүүжилт	
				Эх үүсвэр	Дүн /сая төгрөг/
Дунд хугацааны бодлого					
1	Орхон аймаг, Эрдэнэт хотын ногоон тогтвортой хөгжлийн хэтийн зорилт -2025	4	53	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр	
2	Аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл	1	17	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр	
3	Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	1	10	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр	34,218.0
Богино хугацааны бодлого					
1	Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	1	14	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр	27,737.7
2	Аймгийн 2022 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	1	16	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр	2,201.2
3	Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө	1	16	Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр	2,090.1
Аймгийн дэд хөтөлбөр					
1	Ногоон эрдэнэт хөтөлбөр	3	11	Улс, орон нутгийн төсөв, бусад	90,638.55

Эх сурвалж: Аймгийн бодлогын баримт бичгүүдийн эмхэтгэл, www.erdenet.mn

Аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан 16 арга хэмжээнээс огт хэрэгжээгүй арга хэмжээ байхгүй бөгөөд хэрэгжилтийг бодлогын баримт бичгээр харуулав.

Хүснэгт №2. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт

№	Бодлогын баримт бичиг	Хэрэгжилт			
		2021 он		2022 он	
		тоо	хувь	тоо	хувь
1	Аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл	14	76.0	14	78.8
2	Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	10	86.4	10	90.2
3	Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө	10	90.0	10	92.5

Эх сурвалж: Аймгийн бодлогын баримт бичгүүдийн эмхэтгэл, www.erdenet.mn

“Ногоон Эрдэнэт” хөтөлбөрийн тухайн оны хэрэгжилт, явцыг нэгтгэн дүгнэсэн бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2023 онд хэлэлцэхээр төлөвлөсөн байна.

Мөн Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангуулахаар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар албан даалгаврыг хүргүүлсэн хэдий ч Баян-Өндөр, Жаргалант сумын Засаг дарга нар биелэлтийг тайлагнаагүй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс, албадын ажлын уялдаа муу, хариуцлагагүйгээс шалтгаалан аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн биелэлтийг оновчтой тайлагнаагүй, эрх бүхий байгууллагаар дүгнүүлээгүйд анхаарч ажиллах шаардлагатай байна.

А1.3. Сумдын Засаг дарга нар ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, гэрээг хянаж батлаагүй байна.

Аймгийн Засаг дарга Баян-Өндөр, Жаргалант сумын ойн менежментийн төлөвлөгөөг, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хуульд заасны дагуу хянаж батлах үүрэгтэй.

Аймгийн Засаг дарга Жаргалант сумын 2022-2026 оны ойн менежментийн төлөвлөгөөг, Байгаль орчин, аялал жуулчлалын газар 3 ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө хянаж баталсан байна.

Баян-Өндөр сумын Засаг дарга ойн санг гэрээгээр эзэмшиж буй 5 нөхөрлөлийн 2023 оны ойн санг эзэмших гэрээ байгуулаагүй нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар нөхөрлөлүүдийн 2022 үйл ажиллагааг сонсож, үнэлж дүгнэх шаардлага хангаагүй тул дахин хэлэлцэхээр шийдвэрлэсэнтэй холбоотой ба 2 нөхөрлөл менежментийн төлөвлөгөө батлаагүй байна.

Жаргалант сумын Засаг дарга ойн санг гэрээгээр эзэмшиж буй 9 нөхөрлөлийн ойн сан эзэмших гэрээг хянаж батлаагүй, үр дүн үнэлээгүй, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлээгүй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Орхон аймгийн газар зохион байгуулалтын 2022-2037 оны ерөнхий төлөвлөгөө болон түүнд нийцүүлэн боловсруулсан 2 сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн баталжээ.

Ойн нөхөрлөлүүдийн менежментийн төлөвлөгөө, гэрээг хянаж батлах, түүнд хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хариуцлагатай ажиллаж, хуульд нийцүүлэн ажилласан эсэхийг тодорхойлж, үр нөлөөг сайжруулах хэрэгтэй байна.

1.2 Байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг 2023 оны эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд тусгаж эхэлсэн байна.

А2.1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд аймгийн Засаг даргатай байгуулсан 2023 оны гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон аймгийн Засаг дарга байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээнд 8 зорилт, 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Аймгийн Засаг дарга байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээ, зарцуулах төсвийг байгалийн нөөцийн төрөл бүрээр тусган хэрэгжүүлж ажилласан байна. Харин байгаль нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбоотой харилцааг тусгах, дүгнэх, мэдээллийн сан үүсгэх талаар 2023 онд хэрэгжүүлэх гэрээнд тусгасан байна.

А2.2.Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн байна.

Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд баталсан “Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн, байгальд ээлтэй, дэвшилтэт ногоон технологийг нэвтрүүлж, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулан, нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх замаар байгалийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд 6 зорилтын 73 арга хэмжээг байгууллага тус бүрд хамаарах заалтуудыг тусгаж, хэрэгжилтийг үнэлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг арга хэмжээ бүрээр үнэлсэн хэдий ч хэрхэн үнэлж, зөвлөмж хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй, тухайн байгууллагад зөвхөн үнэлгээг хүргүүлсэн байна.

Хүснэгт №3. Төсөв захирагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

№	Байгууллагын нэр	2021 он				2022 он			
		Дундаж үнэлгээ		Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан		Дундаж үнэлгээ		Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Баян-Өндөр сумын Засаг дарга	112	77.2	11	86.00	106	89.80	10	73.60
2	Жаргалант сумын Засаг дарга	80	83.0	4	97.50	74	89.20	4	100.00
3	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	98	90.8	50	92.00	74	94.20	48	97.20
4	Сум дундын ойн анги	37	85.9	15	88.30	34	90.80	13	86.80

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ-үнэлгээний дүн, байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Байгаль нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбоотой харилцааг тусгах, дүгнэх, мэдээллийн сан үүсгэх талаар 2023 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байна.

БҮЛЭГ 2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журамтай бүрэн нийцээгүй байна.

2.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, ногдуулалт, төвлөрүүлэлтэд тавих хяналт сул байгаагаас орлого бүрэн төвлөрөөгүй байна.

Б1.1. Байгалийн нөөцийг тогтоосон хэдий ч холбогдох хууль, журмыг бүрэн мөрдөөгүй байна.

Аймгийн ургамлын нөөцийн судалгааг 2021 онд ХААИС-ийн Агро экологийн сургуулийн баг хийсэн байна. Харин Ойн нөөцийн судалгааг 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Болор топ ХХК гүйцэтгэсэн ба дахин нөөцийг тодорхойлохоор 2023 оны орон нутгийн хөрөнгө оруулалтад тусгасан байна.

Байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний саналыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2 сумаас авч нэгтгэн, салбарын яаманд хугацаа хоцроож хүргүүлсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/599 дүгээр тушаалаар 2021 оны, 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/217 дугаар тушаалаар 2022 оны ойгоос мод бэлтгэх дээд хэмжээг баталж, 3-4 сарын дараа аймгийн Засаг даргад хүргүүлжээ.

Эдгээр нь Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилт бүрэн хангагдаагүйг илтгэж байна.

Аймгийн газрын төлбөрийн орлогын төлөвлөлтийг Газрын төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор баталсан “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь, үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолуудыг үндэслэн, төлөвлөж батлуулсаар иржээ.

Б1.2.Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцаа журмын дагуу хэрэгжжээ.

Аймгийн байгалийн нөөцийн төлбөрийн орлогыг байгалийн ургамал, ус рашаан, ой болон газрын нөөц ашигласны төлбөрийн орлогоор эх үүсвэрийг бүрдүүлж, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлыг жил бүр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна.

Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгал орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасны дагуу байгалийн нөөцийн орлогын төлөвлөгөөг 2 сумын Засаг дарга, аймгийн Байгал орчин, аялал жуулчлалын газар журамд тусгасан хугацаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ.

Б1.3.Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож буй эсэхэд хяналт хэрэгжүүлэх шаардлагатай болсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан 2021, 2022 онд ойгоос мод бэлтгэх дээд хэмжээг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын дагуу сумын байгаль хамгаалагч нар мод бэлтгэх эрхийн бичгийг олгожээ.

Аймгийн хэмжээнд 2021 онд 348 иргэн, хуулийн этгээдэд ойгоос хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүү цэвэрлэж 3,912.0 шоо метр түлээ бэлтгэхээс 4,236.6 шоо.метр буюу 324.6 шоо метрийг илүү, 2022 онд 325 иргэн, хуулийн этгээдэд ойгоос хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүү цэвэрлэж 3,643.0 шоо метр түлээ бэлтгэхээс 2,800.0 шоо.метр буюу 843.0 шоо метрээр дутуу ашиглах зөвшөөрөл олгож ашигласан байна.

Мөн ургамал ашиглах зөвшөөрөл бүхий 1 ашиглагч 2021 онд 1,500.0 кг элбэг ургамал бэлтгэхээс 200.0 кг, 2022 онд ургамал бэлтгэх хэмжээг батлаагүй байтал 170.0 кг ургамал бэлтгэжээ.

Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар ус ашиглагч 50 иргэн, аж ахуйн нэгж байгаагаас 9 ашиглагч үйл ажиллагаа эрхлээгүй, 20 ашиглагч тоолуур ашигладаг байна. Эдгээрээс ус ашиглах зөвшөөрөлгүй 6, гэрээ байгуулаагүй 20, ус ашиглуулах дүгнэлтгүй 20 ашиглагч үйл ажиллагаа эрхэлж байгаа нь Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т “Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана”, 28.11-д “Энэ хуулийн 28.6-д заасан зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрх бүхий байгууллагаас олгох ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөлгүй, ус ашиглах гэрээ байгуулахгүйгээр үйл ажиллагаа эрхэлж буй Баян-Өндөр сумын 6, Жаргалант сумын 17 ашиглагчийн үйл ажиллагаанд хяналт хийж, холбогдох хууль журамд нийцүүлэх шаардлагатай байна.

Холбогдох хууль, журмын мөрдөхгүй үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоогоогүй, зөрчлийг арилгуулах арга хэмжээг хэрэгжүүлээгүй албан хаагчдын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх шаардлага үүссэн байна. Иймд байгалийн нөөц ашигласны тухай хууль, журмын хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Б1.4.Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөөгүй, ногдуулалт, төвлөрүүлэлтэд тавих хяналт сул байгаагаас орлого бүрэн төвлөрөөгүй байна

Аймгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2021 онд 21,140.0 сая төгрөг, 2022 онд 21,350.0 сая төгрөгөөр Сангийн яам хянасныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хянаж батлан, гүйцэтгэл давж биелсэн байна.

Хүснэгт №4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, биелэлт

Орлогын нэр төрөл	2021 он				2022 он			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Газрын төлбөр	18,386.4	19,083.0	696.6	103.8	21,027.5	23,107.5	696.6	103.8
Ойн нөөц ашигласны төлбөр		27.3	27.3		19.5	20.1	0.6	103.0
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	311.2	352.6	41.4	113.3	351.2	328.7	(22.5)	93.6
Нийт дүн	18,697.6	19,462.9	765.3	102.6	21,398.2	23,456.3	674.7	109.6

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл жил бүр 700.0 сая орчим төгрөгөөр давж биелсэн хэдий ч зарим төрлийн нөөцийн орлого тасарсан шалтгаан нөхцөл байдлын судалгаа хийгээгүй нь тухайн жилийн орлогыг бодитой төлөвлөөгүйг илтгэж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөхдөө ашиглагчийн гэрээ, шинээр олгох зөвшөөрөл, ашиглагчийн тоо хэмжээний өөрчлөлт зэрэг судалгаа тооцоог хийхгүйгээр өмнөх оны төсвийн гүйцэтгэлд тулгуурласан ба аудитаар дүн шинжилгээ хийх баримт материал ирүүлээгүй болно.

Ус рашааны төлбөрийн орлогын төлөвлөгөөг ашиглагчийн ус ашиглуулах дүгнэлт, гэрээтэй тулгахад зөрүү үүссэн бөгөөд татварын систем, байгаль орчны эрх бүхий байгууллагын цахим системүүд хоорондоо уялдаагүй, зөвхөн байгаль хамгаалагч гэрээний дагуу ногдуулалт, нэхэмжлэл үүсгэж, төлбөрийн баримт материалыг шаардан авч, гэрээ дүгнэж байна.

Тус нөөцийн орлогын гүйцэтгэлийн дүнг ТЕГ-аас ирүүлсэн судалгааны дүнтэй тулгахад зөрүү үүссэн ба аймгийн Татварын хэлтэс ашиглагч бүрээр ногдуулалт, төлөлтийн мэдээллийг гаргах боломжгүй тул тулган баталгаажуулаагүй болно.

Томоохон ашиглагч болох Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Ачит ихт ХХК болон Баян-Өндөр сумын ЗДТГ-ын байгаль хамгаалагчийн гэрээ дүгнэсэн акт үйлдсэн ашиглагчийн мэдээллийг тулган баталгаажуулахад усны төлбөрийн орлогыг тайлант онд төвлөрүүлээгүй, гэрээ дүгнэхэд буюу он дамжуулж төлсөн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөн батлуулж, бүрдүүлж ажилласан ч орлогын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүй, гэрээ дүгнэсэн актыг үнэн зөв дүгнээгүй, төлбөрийн илүү дутуу төлөлтийг тооцоолоогүй, төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэлийг бүрэн үүсгэсэн эсэх нь тодорхойгүй зэрэг зөрчлүүд илэрч байна. Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ”, Байгаль орчны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4-т “нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх”, 17 дугаар зүйлийн 17.2.4-т “нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн эрх бүхий байгууллагын ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, ус ашиглах гэрээгүйгээр 6 аж ахуй нэгж үйлдвэрлэл үйлчилгээндээ 2021-2023 онд ус ашигласан нь Усны тухай хуулийн 28.4-д “Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана”, 28.18-д “Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно”, 29.1-д “Энэ хуулийн 28.6, 28.7-д заасан зөвшөөрлийг үндэслэн хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна” гэж заасныг тус тус зөрчиж байх тул 2021-2022 онд ашигласан усны төлбөрийг тооцож, төсөвт төвлөрүүлэх албан шаардлагыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлээ.

Жаргалант сумын байгаль хамгаалагч нарын 2021-2022 онуудын мод ашиглах эрхийн бичиг, ойн нөөцийн төлбөрийн дансны хуулгыг тулган баталгаажуулахад 2.3 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрлээ. Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.2-д “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт төлж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ”, Ойн тухай хуулийн 40.1-д “Ойн баялгийн нөөц ашигласны төлбөрт ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны, ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөр хамаарна”, 40.3-д “Энэ хуулийн 40.1, 40.2-т заасан төлбөр, хураамж, түүнчлэн хууль бусаар бэлтгэж хураалгасан мод, модон материал, ойн дагалт баялгийг борлуулсны орлого, энэ хуулийн 42.1-д заасан нөхөн төлбөрийг хуульд заасны дагуу төсөвт оруулна” гэж заасныг тус тус зөрчиж байх тул төлбөрийн акт тогтоов.

2.2 Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээг мөрдөхгүй төлөвлөж, журамд нийцээгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Б.2.1. Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээг мөрдөхгүйгээр төлөвлөж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг аймаг, сумын төсөвт нэр төрлөөр нь төлөвлөн, батлуулсан байна. Харин байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно” гэж заасан хувь хэмжээгээр тооцохгүйгээр төлөвлөж, тухайн онд санхүүжүүлэх байгаль орчныг хамгаалах төсөл, арга хэмжээний саналыг үндэслэн баталсан байна.

Хүснэгт №5. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөлт /сая.төгрөгөөр/

Байгалийн нөөцийн орлогын төрөл	2021 он			2022 он			2023 он		
	Нийт орлого	Тооцох дүн	Зардлын дүн	Нийт орлого	Тооцох дүн	Зардлын дүн	Нийт орлого	Тооцох дүн	Зардлын дүн
Газар	18,386.4	2,758.0	1,074.0	21,027.5	3,154.1	1,196.5	26,000.0	3,900.0	2,972.9
Ой			298.9	19.5	16.6	679.1			954.9
Ус рашаан	311.2	109.0	64.1	351.2	122.9	58.0	350.0	122.5	180.5
Ургамал			32.0						
Нийт дүн	18,697.6	2,867.0	1,469.0	21,398.2	3,293.6	1,933.6	26,350.0	4,022.5	4,108.3

Эх сурвалж: Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021-2023 оны батлагдсан төсөв

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгалийн нөөцийн нөхөн сэргээлтэд зарцуулах зардлыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээгээр тооцож, төлөвлөх шаардлагатай байна.

Б.2.2. Хууль журамд нийцээгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлсэн байна.

Хүснэгт №6. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэл /сая.төгрөгөөр/

Он	төсөвт төвлөрсөн нийт орлого	Хуулийн дагуу зарцуулбал зохих доод хэмжээ	Зарцуулсан зардал	төлбөрийн орлогын эзлэх хувь	хэрэгжсэн арга хэмжээ	Хууль журамд нийцээгүй арга хэмжээ	
						тоо	дүн
2021	19,463.8	3,009.2	1,110.8	5.7	52	16	425.1
2022	23,456.6	3,598.3	1,563.0	6.7	56	21	744.6

Аймгийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зардалд баталсан 2021 оны 53 төсөл, арга хэмжээнээс 1, 2022 оны 58 төсөл, арга хэмжээнээс 2 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй нь цар тахлын хязгаарлалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээс шалтгаалсан байна.

Харин тус зардлаас 2021-2022 онд Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгал орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заагаагүй 37 төсөл, арга хэмжээнд 1,169.7 сая төгрөгийн арга хэмжээний зардлыг баталж, санхүүжүүлсэн байна.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зардлын төлөвлөлт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилт олгох явцад мэргэжлийн байгууллага болох Байгаль орчин, аялал жуулчлалын газрын оролцоог хангуулах хэрэгтэй байна.

БҮЛЭГ 3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийгээгүйгээс олон нийтийг мэдээллээр хангах, хяналт тавих боломж бүрдээгүй байна.

3.1 Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, төрийн байгууллагуудын уялдаа холбоог оновчтой болгох шаардлагатай байна.

В1.1 Байгаль орчны мэдээллийн санг бий болгож байгаа хэдий ч олон нийтийг мэдээллээр хангах, хяналт тавих боломж бүрдээгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь байгаль орчны мэдээллийн санг цахим хэлбэрээр үүсгэж, улсын хэмжээнд 23 төрлийн мэдээллийг нэгтгэдэг бөгөөд тухайн цахим системүүд нь олон нийтийг мэдээллээр бүрэн хангах нөхцөл бүрэн бүрдээгүй, мэдээллийн сан бүрдүүлэх үйл явц хийгдэж, олон нийт хяналт тавих, мэдээлэл авах боломжийг бүрдүүлээгүй байна.

Сумын Засаг даргын томилсон албан тушаалтан байгалийн нөөц ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг Татварын хэлтэст зөвшөөрөл олгосноос хойш 10 хоногийн дотор гаргаж өгсөн эсэх нь тодорхойгүй, нотлох баримтаар дэмжигдэхгүй байна.

Аймгийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний төсвийн орлогын хэсгийг бүрдүүлэх, төлөвлөх, зарцуулах, хянах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангасан эсэх нь тодорхойгүй бөгөөд төсөв, зардлын гүйцэтгэлийн мэдээллийг erdenet.mn, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн байна.

Байгаль орчны мэдээллийн санд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 12, сумдын байгаль орчны байцаагч 8 мэдээллийг тайлагнах ёстойгоос 2022 онд мэдээллийг иж бүрэн тайлагнаагүй, нэгтгэсэн дүнгээр мэдээлсэн байна.

В1.2 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам бодлого арга зүйгээр хангаж буй ч тухайн орон нутгийн онцлог, нөхцөл байдал, холбогдох хууль, журмын цаглаврыг судлахгүйгээр орон нутгийн төсөв баталсны дараа байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах саналыг хүргүүлдэг байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс нь мэдээлэл, тайланг нэгтгэх чиг үүрэг хэрэгжүүлж, дүн шинжилгээ хийдэггүй, холбогдох байгууллага, нэгжүүдийн уялдааг хангуулан ажиллахад анхаараагүй байна.

Сумын Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулахаар хуульд заасан байтал Баян-Өндөр сумын Засаг дарга томилоогүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, байгаль орчныг хамгаалах зардлын гүйцэтгэлийг аймгийн Санхүү төрийн сангийн төсвийн гүйцэтгэл, харилцах дансны хуулга, Татварын хэлтсийн мэдээ, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын цахим системд нэгтгэсэн тайлангууд зөрүүтэй илэрхийлэгдсэн нь нэгтгэгч байгууллага бүр өөрийн цахим системээр тайлагнаж, үр дүнг нэгтгэж дүгнэдэггүйтэй холбоотой байна.

3.2 Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.

В2.1. Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шинжилгээ хийгээгүй, үр дагаврыг үнэлээгүй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2021-2023 онд аймгийн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шинжилгээ хийгээгүй байна.

Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын харьяа Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Сум дундын ойн анги, сумдын Засаг даргын Тамгын газар, хөрш зэргэлдээ аймгийн сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хамтран, баталсан төлөвлөгөөний дагуу 2021-2023 онд 79 удаагийн шалгалтаар 60 зөрчил илрүүлж, 31 зөрчлийг цагдаа, хуулийн байгууллагад шилжүүлж, 29 зөрчлийг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлж, 1.7 сая төгрөгийн торгууль ногдуулжээ. Хяналт шалгалтын дүн мэдээнээс үзвэл илэрсэн зөрчлийн тоо өсөж, үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байх ба хэрэгжилтийг үнэлээгүй байна.

В2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд хяналт хийгээгүй байна

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, багийн иргэдийн Нийтийн Хурлаас хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2021, 2022 онд зөвхөн тогтоол шийдвэр, хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнг хэлэлцжээ.

Аудитаар илэрсэн зөрчилд 2.3 сая төгрөгт 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгуулж, нөхөн төлбөр ногдуулах 1 албан шаардлага хүргүүлжээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Аймгийн хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилт 90 гаруй хувьтай байна.
- Байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг 2023 оны эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд тусгаж эхэлсэн байна.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, ногдуулалт, төвлөрүүлэлтэд тавих хяналт сул байгаагаас орлого бүрэн төвлөрөөгүй байна.
- Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээг мөрдөхгүй төлөвлөж, журамд нийцээгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

- Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, төрийн байгууллагуудын уялдаа холбоог оновчтой болгох шаардлагатай байна.
- Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийгээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад:

- Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний төсвийг хууль, журамд нийцүүлэн баталж, биелэлтэд хяналт тавьж, үр дүн, хэрэгжилтийг тооцож байх.

Аймгийн Засаг даргад:

- Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч, дотоод хяналтыг сайжруулах.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зардлын төлөвлөлт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилт олгох явцад байгаль орчны байгууллагын оролцоог хангуулах.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт:

- Ойн нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөөг хэлэлцэж, үр дүн, хэрэгжилтийг жил бүр хэлэлцэн дүгнэж байх

Баян-Өндөр, Жаргалант сумын Засаг дарга нарт:

- Байгаль хамгаалагч нарын ажлыг сайжруулж, ажлын гүйцэтгэлийг хянаж, хариуцлагыг сайжруулах.
- Байгалийн нөөцийг ашиглах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээг хууль, журамд нийцүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллах.
- Байгаль орчны мэдээллийн цахим сангийн мэдээллийг үнэн зөв, журамд заасан хугацаанд тайлагнах.

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:

- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэж байх.
- Хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ зориулалтаар ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ байгуулаагүй 23 ашиглагчийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж, хууль журамд нийцүүлж, биелэлтийг нэгтгэж ирүүлэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох баримтын хамт ирүүлнэ үү.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Байгаль орчны цахим систем, Татварын цахим системтэй уялдуулж, эрхийн бичгийг цахим болгох талаар тайланд тусгах.
2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрдүүлэх, тооцооллыг нэгтгэх, мэдээ тайлан гаргах арга зүйн сургалтад байгаль хамгаалагч, байцаагч нарыг хамруулах талаар тусгах

Холбогдох байгууллагын санал:


**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
Цахим шуудан: info@erdenet.mn

2023.06.20 № 03/1540


талбай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай
хуулийн хэрэгжилт, гүйцэтгэлд хийгдсэн аудитын
тайлангийн төсөлд саналгүй болно.

ЗАСАГ ДАРГА  С.БАТЖАРГАЛ



З.Шавзламаа
Аудитор

61235521680



ОРХОН АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМЫН
ЗАСАГ ДАРГА

61025 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Оюут баг
Ш.Отгонбилэгийн гудамж
Утас: 70357965, Факс: 70350965
Цахим хаяг: www.bayanundur.mn
Цахим шуудан: buzdtg@gmail.com

2023.06.20 № 01/830

танай -ны № -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай
хуулийн хэрэгжилт, нийцлийн аудитын тайлангийн төсөлд
хүргүүлэх саналгүй байна.

ЗАСАГ ДАРГА

Б.БААСАНСҮРЭН

Б.Навзмаа
Зүдиг
МБ *11/20*
000000867

D:/My Documents/ A-5. doc



ОРХОН АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА

61010 Орхон аймаг, Жаргалант сум, Жаргалант баг
Нутгийн удирдлагын ордон, Утас: 7039-7203
Цахим хуудас: www.erdenet.mn

2023.06.20 № 01/420

танай -ны № -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай
хуулийн хэрэгжилт" нийцлийн аудитын тайлангийн
төсөлд хүргүүлэх саналгүй болно.

ЗАСАГ ДАРГА

Б.ЗОРИГТБАЯР

Б.Навзмаа
Зүдиг
МБ *11/20*
612201464

D: Aabai Guram A-5